

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

“МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК, “МОНПОЛИМЕТ” ХХК-ИЙН

ХООРОНД БАЙГУУЛСАН МОНЦЕМЕНТ ҮЙЛДВЭРИЙН

ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

Улаанбаатар хот

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль (цаашид "Хөрөнгө оруулалтын тухай хууль" гэх)-ийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам"-ыг үндэслэн:

Нэг талаас:

Монгол Улсын Засгийн газар (цаашид "Засгийн газар" гэх), түүнийг төлөөлж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат;

Нөгөө талаас:

"Монцемент Билдинг Материалс" ХХК (цаашид "Төслийн компани" гэх), түүнийг төлөөлж захирал С.Энхтуяа;

"Монполимет" ХХК (цаашид "Хөрөнгө оруулагч" гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, үүсгэн байгуулагч Ц.Гарамжав

нар (цаашид "Засгийн газар", "Төслийн компани", "Хөрөнгө оруулагч" нарыг хамтад нь "Талууд" гэх), энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд Засгийн газраас Төслийн компанид эрх зүйн баталгаа олгох, татварын болон үйл ажиллагааны орчинг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэр, хугацаа, үе шатыг тодорхойлох, татварын болон татварын бус, зохицуулалтын дэмжлэг үзүүлэх, мөн үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлох, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх байдал, дэд бүтцийн болон бүс нутгийн хөгжил, ажлын байр шинээр бий болгохтой холбогдсон харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.
- 1.2 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж "Хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу 24 (хорин дөрвөн) жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 1.3 "Монцемент Билдинг Материалс" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын бодлогод нийцүүлэн импортыг орлох барилгын материалыг үйлдвэрлэх, шинэ нөү-хау, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилготойгоор орчин үеийн, бүрэн автоматчилагдсан, байгаль орчинд ээлтэй технологи бүхий хуурай аргын цемент шохойн үйлдвэрийг (цаашид "Монцемент үйлдвэрийн төсөл" эсвэл "Төсөл" гэх) олон улсын жишиг, стандартын дагуу 2020 он хүртэл хугацаанд амжилттай бүтээн байгуулж, алслагдсан бүс нутагт эдийн засгийн төрөлжилт, тогтвортой ажлын байрны өсөлтөд хувь нэмрээ оруулна.

- 1.4 Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших "Сэнжит худаг"-ийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх Техник, эдийн засгийн үндэслэл (цаашид "ТЭЗҮ" гэх)-ийг 2013 оны 12 сарын 16-нд Уул уурхайн яам, Ашигт малтмалын газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж дүгнэлт гаргуулсан ба төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 512,2 тэрбум төгрөг (таван зуун арван хоёр тэрбум хоёр зуун сая төгрөг) байхаар тооцоолсон тул "Хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтад тусгагдсан "Хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулах нөхцөл, шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.
- 1.5 Энэхүү Гэрээ нь Төслийн компанийн үйл ажиллагаа явуулах талбайд ашигт малтмал эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, боловсруулах, түүнчлэн тээвэр, эрчим хүч, усны болон бусад дэд бүтцийг барьж байгуулах, тэдгээрийг ажиллуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, уурхайг хаах, байгаль орчны нөхөн сэргээлт хийх, овоолго, хог, хаягдлын асуудлыг шийдвэрлэх зэрэг "Монцемент төсөл"-тэй холбоотой Хөрөнгө оруулагч болон Төслийн компанийн бүхий л төрлийн үйл ажиллагаанд (цаашид "Үндсэн үйл ажиллагаа" гэх) хамаарна.
- 1.6 Хөрөнгө оруулагч нь Сэнжит худгийн ордын 18964А, 13681А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь уурхайн хэсэгт ашигт малтмал олборлох болон боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй. Эдгээр талбай дахь ашигт малтмалын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.
- 1.7 Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог уг Гэрээний 16 дугаар бүлэгт заасны дагуу ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН ОРЧИН

- 2.1 Энэхүү гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа дараахь төрлийн татварын хувь, хэмжээ, түүнийг ногдуулах, төлөх журам, аргачлал, үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт, татвар ногдох орлогыг тооцох журам аргачлал нь Төслийн компанийн хувьд уг гэрээний хугацаанд тогтвортой байна (цаашид "Тогтворжуулсан татвар" гэх)
- 2.1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
 - 2.1.2 Гаалийн албан татвар;
 - 2.1.3 Нэмэгдсэн өртгийн албан татвар;
 - 2.1.4 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/.
- 2.2 Төслийн компани нь энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс хойш дараахь татварыг төлөх үүрэг хүлээхгүй.
- 2.2.1 Энэхүү Гэрээг байгуулсан өдөр мөрдөж байсан Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заагаагүй татвар;

2.2.2 Энэхүү Гэрээг байгуулсан өдөр мөрдөж байсан Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заагаагүй татварыг ногдуулахын тулд аливаа хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Үл тогтворжуулсан татварыг бий болгосны дүнд үүсэх татвар,

2.2.3 Тогтворжуулсан татвартай адилтгах татвар ногдуулахын тулд хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Үл тогтворжуулсан татварыг бий болгосны дүнд үүсэх татвар

2.3 Энэхүү Гэрээ хэлэлцэгдэж буй хугацаанд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан ба хараахан хүчин төгөлдөр мөрдөж эхлээгүй тул 2006 оны 06-р сарын 29-ний өдрийн хууль болон холбогдох журмыг тогтворжуулна.

2.4 Төслийн компанийн үйл ажиллагааны зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу албан татвар ногдох орлогоос хасах, тооцох аргачлал нь энэхүү Гэрээ байгуулагдсан өдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу Гэрээний хугацаанд тогтвортой мөрдөгдөнө.

2.5 Төслийн компанийн татварын тайлангаар гарсан алдагдлыг Гэрээ байгуулагдсан өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын дагуу дараагийн 5 (таван) жилийн албан татвар ногдуулах орлогоос дараалан хасч тооцно. Албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь тухайн жилийн албан татвар ногдуулах орлогын 50 хувиас хэтрэхгүй.

2.6 Хөрөнгө оруулагчийн 1 (нэг) жилээс дээш хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл хорогдлын шимтгэлийг дараахь байдлаар тооцно.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жил/	Элэгдэл тооцох арга	Хөрөнгийн ангилал
1.	Барилга байгууламж	40	Шулуун шугамын аргаар	
2.	Машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10	Шулуун шугамын аргаар	Барилга байгууламж, уурхай болон уурхайн дэд бүтцэд суурилуулсан машин механизм, тоног төхөөрөмж
3.	Компьютер, түүхий эд анги, програм хангамж	3	Шулуун шугамын аргаар	
4.	Ашиглалтын хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10	Шулуун шугамын аргаар	
5.	Ашиглалтын хугацаа нь	Хүчин	Шулуун	

	тодорхой биет бус хөрөнгө, /үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна/	төгөлдөр байх хугацаанд	шугамын аргаар	
6.	Бусад үндсэн хөрөнгө	10	Шулуун шугамын аргаар	
7.	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторх барилга, байгууламж	20	Шулуун шугамын аргаар	
8.	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторх үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, техник, тоног төхөөрөмж	3	Шулуун шугамын аргаар	

2.7 Засгийн газрын 2015 оны 191 дүгээр тогтоолын дагуу Төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн импортолсон, цаашид импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдох гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг гаалийн бүрдүүлэлт хийснээс хойш 2 жилээр сунгаж хойшлуулах ба татварын эргэн төлөлтийн хуваарийг Сангийн яамтай байгуулсан гэрээгээр зохицуулна. Бусад Гаалийн татварыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль (энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан)-ийн дагуу ногдуулна.

2.8 Төсөлд зориулан Хөрөнгө оруулагч болон Төслийн компанийн авч ашигласан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

2.9 Талууд дараахь зүйлийн талаар харилцан тохиролцов:

2.9.1 Энэхүү Гэрээ байгуулсан өдрөөс хойш батлагдсан аливаа хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон татварын хувь хэмжээ нь энэхүү Гэрээний 2.1-д заасан татварын хувь хэмжээнээс доогуур тогтоогдсон, эсхүл энэхүү Гэрээнд заасан Хөрөнгө оруулагчийн төлбөл зохих татварыг бууруулах тохиолдолд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Төслийн компани уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтөд хамаарахгүй.

2.9.2 Энэхүү Гэрээний 2.9.1-д заасны дагуу хувь хэмжээ буурсан татвар нь эргэн Тогтворжуулсан татварын хувь хэмжээнээс давсан тохиолдолд Төслийн компани нь Гэрээ байгуулах үеийн Тогтворжуулсан татварын хувь хэмжээг мөрдөнө.

- 2.10 Тогтворжуулсан татвараас бусад татварыг үл ялгаварлах зарчмаар Төслийн компанид ногдуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН БУС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ

- 3.1 Засгийн газар нь Төслийн компанид дор дурдсан татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Газрыг 15-60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна;
 - 3.1.2 Төслийн болон дэд бүтцийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд Хөрөнгө оруулалтын тухай хууль (энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан)-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасан дэмжлэг;
 - 3.1.3 Гадаадын банк санхүүгийн байгууллагаас Төсөлд зориулж зээл авах тохиолдолд Засгийн газрын боломжит дэмжлэг;
 - 3.1.4 Бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор үйлдвэрлэлийн технологид нийцсэн түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутгаас олборлох, худалдан авах боломжоор хангахад хууль, тогтоомжид заасан дэмжлэг;
 - 3.1.5 Үйлдвэржилтийг дэмжих тухай хуульд заасан дэмжлэг;
 - 3.1.6 Хуульд заасан бусад дэмжлэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨСЛИЙН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 4.1 Төслийн компанийн хэрэгжүүлж буй Монцемент үйлдвэр жилдээ 984,000 /есөн зуун наян дөрвөн мянган/ тонн чулуунцар (клинкер), РС 42.5, РС 52.5, ОРС 42.5 төрлийн 1,000,000 (нэг сая) тонн цемент, 100,000 (нэг зуун мянга) тонн барилгын болон металлургийн шохой болон эдгээр дээр суурилсан бусад барилгын материал үйлдвэрлэнэ.
- 4.2 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай байна.
- 4.3 Хөрөнгө оруулагч нь Гэрээ байгуулагдсан өдрийг хүртэл нийт 463.4 /дөрвөн зуун жаран гурав аравны дөрвөн/ тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Хүлээгдэж буй хөрөнгө оруулалт нь 48.8 (дөчин найм аравны найман) тэрбум төгрөг болно.
- 4.4 Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтыг дараахь хуваарийн дагуу хийнэ. Төслийн хэрэгжилтийн явцад Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь шаардлагатай тохиолдолд тухайн жилийн хөрөнгө оруулалтын хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

Д/д	Хөрөнгө оруулалт	Хэмжих нэгж	Нийт	Хөрөнгө оруулалтын хугацаа
1	Хийгдсэн хөрөнгө оруулалт	сая.төг	463,436.22	2009-2015
2	Хийгдэх хөрөнгө оруулалт			
2.1	Ажилчдын хотхон	сая.төг	29,200.00	2016-2020
2.2	Ил уурхай	сая.төг	13,170.00	2016-2018
2.3	Цахилгаан станц	сая.төг	6,401.18	2017-2020
	Нийт	сая.төг	512,207.40	

4.4.1 Төслийн үлдэгдэл хөрөнгө оруулалт болох 48.8 (дөчин найм аравны найман) тэрбум төгрөгийг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ.

- Гадаад улсын банк эсвэл бусад банкнаас авах 29.3 (хорин ес аравны гурван) тэрбум төгрөгийн зээл;
- Хөрөнгө оруулагчаас оруулах 19.5 (арван ес аравны тав) тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болно.

4.4.2 Монцемент үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулалтын зориулалт, задаргаа:

Д/д	Хэсэг нэгж	Нийт
1	Цементийн үйлдвэр	380,204.30
2	Ил уурхай	18,986.40
3	Үйлдвэрийн оффис	17,900.70
4	Ажилчдын хотхон	39,568.00
5	Дэд бүтэц	50,727.60
6	Төв оффис (УБ)	2,225.30
7	Хайгуулын ажлын зардал	595.2
8	Туршилт судалгаа	2,000.00
	Нийт	512,207.40

4.6 Төслийн компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг зах зээлийн үнэлгээгээр тооцно. Харилцан хамаарал бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үнийг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг баримтална.

ТАВДУГААР БҮЛЭГ
ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ,
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР

- 5.1 Төслийн компани нь Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" багц хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 5.2 Төслийн компани нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох төрийн байгууллагаар баталгаажуулан түүнийг мөрдөж ажиллана.
- 5.3 Үйлдвэрийн барилга угсралт, ашиглалт болон засвар үйлчилгээний ажлын үе шатуудад байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн хариуцлагын хүрээний ажлуудыг зохион байгуулах компанийн нэгдсэн бодлогыг бий болгоно.
- 5.4 Төслийн компани өөрийн эзэмшиж, ашиглаж буй газар, тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Гүйцэтгэлийн Шаардлага №1-10-т тавигддаг стандарт, шаардлагын дагуу эрүүл мэнд, байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлт, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллана.
- 5.5 Дорноговь аймгийн Өргөн сум орчимд төслийн компани гүний усны хайгуул судалгааг явуулснаар Монцемент төсөл болон Өргөн сумын иргэдийн усны хэрэглээг хангах бололцоог судалж ажиллана.
- 5.6 Уурхай болон үйлдвэрийн бүсийн орчим дахь газрын доройтлыг бууруулж, цөлжилтийг сааруулах, элсний нүүдлийг зогсоох зорилгоор ховордсон болон говийн бүсэд ургадаг мод тарих замаар ойн төгөл зурвасуудыг байгуулна.
- 5.7 Төслийн компани нь Монгол Улсын барилга болон эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт анх удаа үйлдвэрийн хаягдал халуун хийг ашиглан цахилгаан үүсгэх 5 Мвт-ын хүчин чадал бүхий эрчим хүчний үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулснаар эрчим хүчний системээс авах ачааллыг 30%-40% бууруулна.
- 5.8 Төслийн компани нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр тухайн жилд төсөвлөсөн зардлыг хууль тогтоомжинд заасан тусгай дансанд байршуулна.
- 5.9 Төслийн компани нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэн, орон нутгийн комисст хүлээлгэн өгч дүгнэлт гаргуулна.
- 5.10 Үйлдвэрлэлийн болон орд ашиглах үйл ажиллагааны үр дүнд агаар, ус, хөрс, ан амьтан, ургамал болон газрын хэвлийд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн нь тогтоогдвол Төслийн компани нь түүний үр дагаврыг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

- 5.11 Төслийн компани нь үйлдвэрийн түүхий эд нийлүүлэх ордын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж ажиллах ба уурхай хаах үед тавигдах шаардлагыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу бүрэн биелүүлэх үүрэгтэй.
- 5.12 Төслийн компани нь уурхайн ашиглалтын дараахь нөхөн сэргээлтийн дараа талбайг эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар судалгаа, шинжилгээ хийж төлөвлөгөө батлуулан ажиллана.
- 5.13 Төслийн компани нь Говийн бүсэд тохирсон ахуйн болон үйлдвэрийн усны хэрэглээ багатай технологийг сонгож, ашиглагдсан усны 90%-ийг цэвэршүүлэн дахин ашиглах систем бүхий цэвэршүүлэх байгууламжийг байгуулна. Цэвэршүүлсэн усыг үйлдвэрийн шат дамжлагад дахин ашиглах, байгаль орчинд тархах тоосжилтыг дарах зэргээр ашиглана.
- 5.14 Төслийн компани нь байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 (хоёр) жил, усны бүрэн аудитыг 5 (таван) жил тутам явуулах, үүнд гүний усны түвшинг болон өнөөгийн хэрэглээнээс үүсч буй нөлөөллийг хэмжих ажлууд багтана.
- 5.15 Дорноговь аймгийн Өргөн сумын 4325.1 км² нутаг дэвсгэрийг хамарсан газар нутагт биологийн олон янз байдал, ховор болон ховордож буй амьтан ургамлын аймгийн талаарх судалгааны ажлыг гүйцэтгэнэ. Төслийн хүрээнд байгаль орчин, биологийн төрөл зүйлийн судалгааны хувьд шохойн чулууны орд, цементийн үйлдвэр, зам, төмөр зам, ус татах хоолой, цахилгааны шугамын төслүүдийн талбайн экологийн хэсгүүд хамаарна.
- 5.16 Тоосжилт болон хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээ нь Хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжих, хянах, нотлох тайлагнах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.
- 5.17 Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээчийн багаар тогтоолгож болох бөгөөд нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай бол санхүүжилтийг шийдвэрлэнэ.
- 5.18 Төслийн компани нь төслийг хэрэгжүүлэх явцад биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулж, орон нутагтай хамтран ажиллана.
- 5.19 Төслийн компани нь уурхайн болон үйлдвэрлэлийн бүсэд хүн ам, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх аюултай хог хаягдал хаяхгүй байж, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 заалтыг хэрэгжүүлж ажиллана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

- 6.1. Орон нутгийн засаг захиргааны зүгээс хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагааг Төслийн компани дэмжин ажиллана.
- 6.2. Төслийн компани нь бүс нутагт болон орон нутагт хэрэгжүүлэх нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай, олон нийтийн оролцоог хангах зарчмыг баримталж ажиллана.
- 6.3. Төслийн компани нь Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулна.
- 6.4. Төслийн компани нь Дорноговь аймгийн Өргөн сум болон тус аймгийн бусад сумдын иргэдийг сургах, ажлын байраар хангах талаар тэргүүн ээлжинд анхаарна.
- 6.5. Төслийн компани нь Дорноговь аймгийн Өргөн суманд хүүхдийн цэцэрлэг, худалдааны цогцолборыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулна.
- 6.6. Төслийн компани нь Монцемент үйлдвэрт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжин ажиллана.
- 6.7. Төслийн компани нь Дорноговь аймгийн Өргөн суманд 220 айлын орчин үеийн, дэд бүтцэд бүрэн холбогдсон орон сууцны хотхонг өөрийн хөрөнгөөр барьж байгуулна.
- 6.8. Төслийн компани нь орон нутгийн ард иргэдийн ёс заншил, өв уламжлалыг хүндэтгэн ажиллана.
- 6.9. Төслийн компани нь үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд бараа, материал, техникийн сэлбэг, эд ангийг Монголын үндэсний компани, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхэд давуу эрх олгож ажиллана.

ДОЛДУГААР БҮЛЭГ ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

- 7.1. Засгийн газар нь эрчим хүчний холбогдох зөвшөөрлийг Төслийн компанид аль болох шуурхай олгох бөгөөд зөвшөөрлийг Эрчим хүчний тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар зөвшөөрсөн хамгийн дээд хугацаагаар олгож, сунгуулах эрхтэйгээр энэхүү Гэрээний хүчинтэй хугацаанд олгоно.
- 7.2. Монцемент үйлдвэрийн хэрэгцээ, шаардлага, бүтээн байгуулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэхийн тулд эрчим хүчний хамгийн зохистой, найдвартай эх

үүсвэрээр хангах талаар Засгийн газар, Хөрөнгө оруулагч, Төслийн компани хамтран ажиллана.

- 7.3. Засгийн газар Монцемент үйлдвэрийг эрчим хүчээр хангахдаа эрчим хүчний эх үүсвэр, үнэ, тариф, төлбөр, хураамжийг үл ялгаварлах зарчимд тулгуурлан тогтооно.
- 7.4. Монцемент үйлдвэрт шаардагдах усны хэрэгцээг хангах зорилгоор гүний усны нөөцийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд холбогдох зөвшөөрлийг олгоход Засгийн газар хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
- 7.5. Төслийн компани нь өөрийн эзэмшлийн дэд бүтцийн тодорхой байгууламж, түүний үйлчилгээг Монцемент үйлдвэрийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлд бүс нутгийн болон бусад гуравдагч этгээдэд гэрээгээр ашиглуулж болно.
- 7.6. Төслийн компани нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэмэлт газар шаардагдах тохиолдолд газар эзэмших, ашиглах хүсэлтийг төрийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад гаргах ба Засгийн газар хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
- 7.7. Уул уурхайн зориулалтаар ашигласан газрыг нөхөн сэргээхтэй холбоотой бүх асуудлыг Ашигт малтмалын тухай хууль, газар ашиглах гэрээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, мөн энэхүү Гэрээнд тусгайлан заасны дагуу Төслийн компани бүрэн хариуцна.
- 7.8. Төслийн компанийн эзэмшиж, ашиглаж буй газраас тусгай хэрэгцээ, тусгай хамгаалалт, нөөцөд тодорхой хэмжээний газрыг авахтай холбоотой харилцааг Газрын тухай хууль, тогтоомжийн дагуу зохицуулж, холбогдох нөхөн олговрыг олгоно.
- 7.9. Хуульд заасан хугацаа дуусгавар болохоос бусад тохиолдолд, мөн Газрын тухай хууль, тогтоомжид заасны дагуу Талууд харилцан тохиролцоогүй бол Төслийн компанийн газар эзэмших ашиглах эрх уг гэрээний 3.1.1-т заасан хугацаанд хүчин төгөлдөр байна. Газар эзэмших, ашиглах гэрээ дуусгавар болох тохиолдолд тухайн газар дээр байрлах Төслийн компанийн өмчлөлд байгаа үйлдвэр, барилга байгууламж, шугам сулжээ, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нь Төслийн компани хэвээр байна.
- 7.10. Төслийн компани нь улсын болон орон нутгийн чанартай авто зам, дамжуулах хоолой, бусад тээврийн байгууламжийг барьж байгуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсын авто зам, тээврийн нэгдсэн сүлжээ, хөгжлийн стратеги, бодлоготой уялдуулна.

- 7.11 Засгийн газар нь Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10-д заасан нөхцлийг хангасан тохиолдолд Төслийн компанид газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 8.1. Төслийн компани нь Монцемент үйлдвэрт ажиллах инженер техникийн ажилтан, ажиллагсдыг сургалтын тусгай төлөвлөгөөний дагуу дотоод, гадаадын их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд давтан сургах замаар мэргэжилтэй ажилтан шинээр бэлтгэнэ.
- 8.2. Төслийн компанийн нийт ажиллагсдын 10 хүртэлх хувьд хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсны үндсэн дээр гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулж болно. 2018 оныг дуустал бүтээн байгуулалтын ажил явагдах жилүүд болон операторын үйлчилгээ үзүүлэх /Operation and Maintenance (O&M)/ компани ажилуулах хугацаанд дээрх хязгаарлалт хамаарахгүй.
- 8.3. Бүрэн автомат, хуурай аргын технологи дээр суурилсан гадаадын ижил төстэй үйлдвэрт Монгол Улсын инженер, техникийн ажилтнуудыг дадлагажуулан сургаж, ажлын байраар хангана.
- 8.4. Монцемент үйлдвэрийн төслийн барилга бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, Операторын үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу зайлшгүй шаардлагатай гадаад ажиллагсдын Монгол Улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Засгийн газар холбогдох хуулийн дагуу олгож, хугацааг сунгахад дэмжлэг үзүүлж ажиллана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 9.1. Засгийн газар нь Төслийн компанийн үйл ажиллагаагаа явуулах татварын болон тогтворжуулсан татварын орчинг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтвортой байлгах үүргийг хүлээнэ.
- 9.2. Засгийн газар нь энэхүү Гэрээний хэрэгжилтийг хангах, Гэрээнд заасан хамтын зорилтуудад хүрэхийн тулд боломжит бүх арга хэмжээг авч ажиллана.
- 9.3. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болмогц Засгийн газар Гэрээний нөхцөл, бусад мэдэгдлийг холбогдох яам, агентлаг, төрийн захиргааны ба орон нутгийн байгууллагуудад хүргүүлнэ.
- 9.4. Засгийн газар нь үйлдвэрлэл эрхлэх, Төслийн үндсэн болон туслах үйл ажиллагаанд холбогдох эрх, тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомж,

журамд зааснаас бусад тохиолдолд Гэрээний хүчинтэй хугацаанд цуцлахгүй, хүчингүй болгохгүй.

- 9.5. Энэхүү Гэрээний хугацаанд Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх, оюуны өмч, тусгай зөвшөөрлийг Засгийн газар хураан авахгүй, төрийн өмчид шилжүүлэхгүй.
- 9.6. Төслийн компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс Хөрөнгө оруулагч болон Төслийн компаниас Засгийн газар, төрийн захиргааны байгууллагад хандан гаргасан шаардлагатай бүхий л эрх, зөвшөөрөл, хүсэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шуурхай шийдвэрлэхэд Засгийн газар дэмжлэг үзүүлнэ.
- 9.7. Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн аливаа эд хөрөнгийг хууль бусаар дайчлан авахгүй. Хэрэв Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу нийтийн ашиг сонирхлын үүднээс дайчлан авах шийдвэр гарсан тохиолдолд Засгийн газар нь Төслийн компани, Хөрөнгө оруулагчид учрах аливаа хохирлыг дайчлан авах үеийн зах зээлийн үнэлгээгээр хамтран тооцож нөхөн олговрыг олгоно.
- 9.8. Засгийн газар нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Хөрөнгө оруулагч болон Төслийн компаниас холбогдох мэдээ, тайлан гаргуулах, Төслийн үйлдвэртэй танилцах эрхтэй.
- 9.9. Засгийн газар нь Хөрөнгө оруулагч болон Төслийн компаниас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас үүссэн хохирол, ногдуулах байсан татварын зөрүүг нэхэмжлэх эрхтэй.
- 9.10. Төслийн хүрээнд үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүнийг шударгаар өрсөлдөх нөхцлийг "Өрсөлдөөний тухай хууль"-ийн хүрээнд зохицуулна.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨСЛИЙН КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 10.1. Монцемент үйлдвэрт оруулсан Төслийн компанийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, Улсын Их Хурлаас соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалтад байна.
- 10.2. Төслийн компани нь Монцемент үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, компанийн санхүүгийн асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй.
- 10.3. Төслийн компани нь Гэрээний 4.1-т заасан хүчин чадал бүхий үйлдвэрийг барьж байгуулах, Гэрээний 4.3-т заасан хөрөнгө оруулалтыг хийх үүрэгтэй.

- 10.4. Төслийн компани нь ашигт малтмалын 13964А, 13681А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй.
- 10.5. Төслийн компани нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- 10.6. Төслийн компани нь өөрийн тодорхойлсон менежмент, маркетингийн зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.
- 10.7. Төслийн компани нь бэлэн мөнгө, техник тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх зэрэг хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүх хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх эрхтэй.
- 10.8. Төслийн компани нь Монгол Улсын болон бусад улсын арилжааны банкинд данс нээж сонгосон валютаараа гадаад гүйлгээг чөлөөтэй, саадгүйгээр хийх эрхтэй.
- 10.9. Төслийн компани нь Засгийн газраас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
- 10.10. Төслийн компани нь хөрөнгө оруулалт, Төслийн хэрэгжилтийн талаарх тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгөх үүрэгтэй.
- 10.11. Төслийн компани нь бүтээгдэхүүнээ урьдчилан худалдах замаар олсон орлого, санхүүжилтийг гадаад улсын банк, санхүүгийн байгууллагад төвлөрүүлэх, зээлдүүлэгчид шууд шилжүүлэх эрхтэй бөгөөд үүнээс бусад тохиолдолд үйлдвэрийн орлогыг Монгол Улсын арилжааны банкинд төвлөрүүлнэ.
- 10.12. Төслийн компани нь Монгол Улсад газрын тос боловсруулах, нүүрс-хими, кокс-хими, хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулахад дэмжиж ажиллана.
- 10.13. Төслийн технологи, эдийн засгийн тооцоололд сөрөг нөлөө үзүүлэхгүй тохиолдолд төслийн компани нь гелтгэнийг дотоодын зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс авна.

**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 11.1. Хөрөнгө оруулагч нь Төслийн компанид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татах, эх үүсвэрийг тодорхойлох, үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхтэй.

- 11.2. Монцемент үйлдвэрт оруулсан Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, Улсын Их Хурлаас соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалтад байна.
- 11.3. Хөрөнгө оруулагч нь Засгийн газраас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
- 11.4. Хөрөнгө оруулагч нь Гэрээний 4.4-т заасан хөрөнгө оруулалтыг хуваарийн дагуу хийх үүрэгтэй.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 12.1. Энэхүү Гэрээ нь дараахь тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 12.1.1 Гэрээний хүчинтэй хугацаа дууссаны дараа Талууд хугацааг сунгаагүй бол;
- 12.1.2. Аль нэг тал нь Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасны дагуу Талууд харилцан тохиролцсон бол;
- 12.1.3 Түүхий эдийн нөөц дууссан бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогссон бол.
- 12.2. Энэхүү гэрээ дуусгавар болсон нь Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн эзэмшиж ашиглаж буй эрх, тусгай зөвшөөрлүүд, Төслийн компани болон Хөрөнгө оруулагчаас Засгийн газар, төрийн байгууллагуудтай байгуулсан бусад гэрээний эрх, үүргийг дуусгавар болгох, хязгаарлах, цуцлах үндэслэл болохгүй.
- 12.3. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээг түдгэлзүүлэх, цуцлах эрх Засгийн газарт байна.
- 12.4. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Засгийн газар Гэрээг түдгэлзүүлэх, цуцлах татварын болон татварын бус дэмжлэг, тогтворжуулалтыг хүчингүй болгож нөхөн төлбөр нэхэмжлэхээс өмнө Төслийн компани, Хөрөнгө оруулагч нарт урьдчилан мэдэгдэж үүргийн зөрчлийг арилгах хугацааг 12 (арван хоёр) хүртэл сараар олгоно.
- 12.5. Засгийн газар Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол Хөрөнгө оруулагч, Төслийн компани нь энэхүү Гэрээг түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгохоос өмнө Засгийн газарт урьдчилан мэдэгдэх бөгөөд Засгийн газрын уг зөрчлийг арилгах хугацаа 12 (арван хоёр) хүртэлх сар байна.
- 12.6. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Засгийн газраас тавьсан шаардлагыг хүлээн авснаас хойш 1/ нэг/ сарын дотор тайлбар, санал, хүсэлт гаргаж болно.

- 12.7. Гэрээний 12.4-т заасан хугацаа нь тухайн үүргийн зөрчлийг арилгахад хүрэлцэхгүй тохиолдолд Теслийн компани, Хөрөнгө оруулагчийн хүсэлтийг харгалзан 12 (арван хоёр) сар хүртэлх хугацаагаар сунгаж болно.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 13.1. Давагдашгүй хүчин зүйлс гэдэгт газар хөдлөлт, хүчтэй салхи, түймэр, аянга, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, цацраг идэвхит бодисын хордуулалт, олон улсын шинжтэй хилийн боомт хаагдах, хөдөлмөрийн маргаанаас үүссэн өргөн хэмжээний эмх замбараагүй байдал, нийтийг хамарсан өвчин тахал, дайн, дайн бүхий байдал, хорио цээр зэрэг нийгмийн онцгой байдал, санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан эдийн засгийн боломжит цар хүрээ хумигдсан, Талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдал зэрэг энэхүү Гэрээний аль нэг талын хяналтаас давсан үйлдлийг ойлгоно.
- 13.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Талууд нь Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлж чадаагүй бол тухайн давагдашгүй хүчин зүйлийн хугацаанд аль нэг тал хариуцлага хүлээхгүй.
- 13.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ биелүүлж чадахгүй болсон Тал нь энэ тухай нөгөө талдаа бичгээр шуурхай мэдэгдэх бөгөөд Талууд боломжтой бүх арга хэмжээг авах, шалтгааныг арилгахын төлөө хамтран ажиллана.
- 13.4. Энэхүү Гэрээний аль нэг тал Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл хойшлуулсан тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн үр дагаврыг арилгах боломжит хугацаа болон тухайн ажлыг эхлүүлэх буюу үргэлжлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын бодит хугацаагаар Гэрээг сунгана.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 14.1. Хэрэв Талуудын хооронд энэхүү Гэрээ, түүний хэрэгжилттэй холбоотой маргаан, санал зөрөлдөөн эсхүл үл ойлголцол (цаашид "Маргаан" гэх) үүссэн тохиолдолд тухайн Тал нь үүсээд буй Маргааныг Гэрээний 14.2-т заасан журмын дагуу шийдвэрлэх тухай мэдэгдэл (цаашид "Маргаан шийдвэрлэх мэдэгдэл" гэх)-ийг Талуудад хүргүүлнэ.
- 14.2. Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх:
14.2.1. Маргаан шийдвэрлэх мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 60 хоногийн дотор Талууд Маргааныг эв зүйгээр шийдвэрлэнэ. Энэ хугацаанд эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй бол Маргааныг шийдвэрлэх эрх бүхий төлөөлөгчдийг Талууд томилно.

14.2.2. Эрх бүхий этгээдүүдийг томилсноос хойш ажлын 60 хоногт Маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн дээд түвшний удирдлага, Засгийн газрын гишүүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид эвлэрлийн хэлэлцээ хийнэ.

14.3. Маргаан шийдвэрлэх мэдэгдлийг анх хүргүүлснээс хойш ажлын 120 хоногийн хугацаанд Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол Маргааныг Монгол Улсын "Арбитрын тухай" хуулийн дагуу МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитраар шийдвэрлүүлнэ.

14.4. Арбитрын шийдвэр нь эцсийнх бөгөөд уг шийдвэрийг Талууд биелүүлнэ.

14.5. Гэрээний 14 дүгээр зүйлд заасан маргаан шийдвэрлэх заалт нь Гэрээ хүчин төгөлдөр байх, Гэрээний хугацаа дууссаны дараа, эсхүл Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсаны дараа Талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбогдсон аливаа маргаанд адил хамаарна.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

15.1. Талууд хэлэлцээ хийж тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх эрхтэй.

15.2. Энэхүү Гэрээ нь Засгийн газрын харьяа байгууллага болон гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжтэй Монцемент үйлдвэрийн төслийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, санамж бичиг байгуулах Талуудын эрхийг хязгаарлахгүй.

15.3. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бүрэн эрх, Гэрээ байгуулах хууль ёсны итгэмжлэлтэй болохоо харилцан баталгаажуулав.

15.4. Хэрэв Гэрээний аль нэг заалт тодорхой шалтгаанаар хэрэгжих боломжгүй бол тухайн заалтыг Гэрээнээс тусад нь авч үзэх бөгөөд энэхүү Гэрээний бусад хэсэг хүчин төгөлдөр үйлчилнэ.

15.5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Төслийн ТЭЗҮ-ийн гол үзүүлэлтэд өөрчлөлт орсон тохиолдолд хөрөнгө оруулагчийн санаачлагаар гэрээнд өөрчлөлт оруулж болно.

15.6. Талууд Гэрээний дагуу аливаа мэдэгдэл, бусад харилцааг бичгээр үйлдэх бөгөөд тухайн баримт бичгийг биечлэн, эсхүл шуудан, факсаар илгээн, шуудангийн салбарт хүргэснээр тухайн баримт бичгийг зохих ёсоор хүлээлгэн өгсөнд тооцно.

15.7. Хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, Улсын Их

Хурлаас соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу зохицуулна.

- 15.8. Энэхүү Гэрээг монгол хэл дээр 3 (гурван) хувь үйлдэж, Талууд тус бүр 1 (нэг) хувийг хадгална.
- 15.9. Энэхүү Гэрээг байгуулснаас хойш зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамаарч Монцемент үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэх бол Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

АРВАНЗУРГААДУГААР БҮЛЭГ НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томьёо нь дараахь агуулгыг илэрхийлнэ. Үүнд:

- 16.1. **“Техник, эдийн засгийн үндэслэл”** гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, олон улсад мөрддөг стандарт, шаардлагын дагуу геологи хайгуул, техник технологийн бүрэн хэмжээний судалгаа шинжилгээний мэдээлэл дээр үндэслэгдсэн эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалт, байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийн тооцоолон тодорхойлсон баримт бичгийг;
- 16.2. **“Монцемент үйлдвэр”** гэж жилд 984,000 тонн чулуунцар, 1,000,000 тонн цемент, 100,000 тонн барилгын болон металлургийн шохой үйлдвэрлэх боломжтой үйлдвэрийг;
- 16.3. **“Засгийн газар”** гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1–д заасныг;
- 16.4. **“Төслийн компани”** гэж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн 9011047076 дугаар, ашигт малтмалын 18964А, 13681А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшигч “Монцемент Билдинг Материалс” ХХК-г болон түүний эрх үүргийг шилжүүлэн авсан этгээдийг;
- 16.5. **“Хөрөнгө оруулагч”** гэж “Монполимет” ХХК-г;
- 16.6. **“Төслийн үйл ажиллагаа”** гэж Монцемент үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах, тэдгээрийг ажиллуулах, дагалдах түүхий эд (шохойн чулуу, гөлтгөнө, элс, шавар, нүүрс гэх мэт)-ийг эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ялган авах, олборлох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэр, уурхайг хаах, байгаль орчны нөхөн сэргээлт хийх зэрэг Төсөлтэй холбоотой Төслийн компани болон хөрөнгө оруулагч, гэрээлэгч бусад этгээдийн бүхий л төрлийн үйл ажиллагааг;
- 16.7. **“Татварыг үл ялгаварлах зарчмаар ногдуулах”** гэж татварын болон бусад эрх бүхий байгууллагаас ногдуулсан татвар, түүний хувь хэмжээ, татварын

шаардлага нь бусад аж ахуйн нэгж, компани, татвар төлөгчдөд ногдуулж буй татвараас илүүгүй хувь хэмжээгээр ногдуулсан, тооцсон аргачлал нь ижил бөгөөд эрх зүйн байдлыг дордуулаагүй, татварын дарамт учруулахгүй байхыг;

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:




ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД
/Д.ЭРДЭНЭБАТ/

“МОНЦЕМЕНТ БИЛДИНГ
МАТЕРИАЛС” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:



“МОНПОЛИМЕТ” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ҮҮСГЭН
БАЙГУУЛАГЧ
/Ц.ГАРАМЖАВ/